

## ТӨВ БАНКНЫ ТЭНЦЭЛ, ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЛААР

**Мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Б. Отгондорж**

### *ОРШИЛ:*

Бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, эсвэл арилжааны банкуудын удирдлага нь тайлан, тэнцлийг хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө үйл ажиллагаагаа тайлагнах нэгэн арга хэлбэр болгон хэрэглэдэг. Иймд тухайн нэгжийн үйл ажиллагаа нь ашгийнхаа хэмжээгээр болон компанийн тухайн үе дэх үнэ цэнээр илэрхийлэгддэг. Харин Төв банкны тайлан тэнцэл нь үйл ажиллагааных нь үр дүнг шууд харуулах эцсийн шалгуур биш юм. Гэвч Төв банкны тэнцэл, орлого, зарлагын тайлангаас мөнгөний бодлогын хэрэгжилтэнд ямар хүчин зүйлс нөлөөлж байгаа, байгууллагын зохион байгуулалт, хууль эрх зүйн орчин, цаашилбал Төв банкны бие даасан байдлын талаархи мэдээллийг авч болдог гэж үздэг.

Энэхүү танилцуулгаар гадаад валютын интервенци эсвэл банкны системийн өөрчлөлт, засгийн газарт зээл олгох, үнэт металл, валютын арилжаа гэх мэт үйл ажиллагаа нь Төв банкны орлого, зарлагад хэрхэн тусгагдаж байгаа, тэдгээрийн гол бүрдүүлэгч хэсгүүд хэрхэн өөрчлөгдж ирснийг харуулах, шинээр бий болсон орлого, зарлагууд нь нийт ашиг алдагдлын хэмжээнд хэрхэн нөлөөлсөн зэргийг авч үзнэ. Түүнчлэн, Төв банкны ашигт ажиллагааны байдал нь өөрийн хөрөнгөнд нь хэрхэн нөлөөлж тэр нь Төв банкны бие даасан байдалд хэрхэн тусгагдаж болох талаар бичлээ.

Төв банкны хувьд өөрийн хөрөнгө чухал уу?

Ерөнхийдөө Төв Банкны өөрийн хөрөнгө нь арилжаалагддаггүй буюу өөрөөр хэлбэл бусдад худалдагдах эсвэл хувьцаа гарган борлуулах маягаар эзэмшил нь өөрчлөгднө гэсэн ойлголт байдаггүй. Төв банкны өөрийн хөрөнгө нь шууд бусаар Засгийн газрын татвараа нэмж, орлогоо өсгөх боломжоор баталгаажсан байdag бөгөөд Засгийн газар бонд гаргах замаар Төв банкийг дахин хөрөнгөжүүлэх бололцоотой. Төв банкны өөрийн хөрөнгийг аль болох бага хэмжээнд байлгах нь улсын хөрөнгийг оновчтой зарцуулах сайн талтай гэж үзэх

үндэслэл байдаг. Түүнчлэн, бага өөрийн хөрөнгөтэй Төв банк мөнгөний захын эцсийн зээлдэгчийнхээ хувьд илүү хянамгай, "консерватив" ханддаг бөгөөд үүгээрээ банкууд "moral hazard" үүсгэх эрсдлийг бууруулдаг гэж үздэг. Өндөр хөгжсөн болон шинээр үүсж буй эдийн засгуудын аль алиных нь хувьд Төв банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа маш бага байдаг. Зарим улсад, Төв банкны өөрийн хөрөнгийн байвал зохих хэмжээг тодорхойлон тавьдаг. Жишээлбэл, хуулийн дагуу Индонезийн Төв банк нь өөрийн хөрөнгөө нийт өглөгийнхөө 10 хувьд хүрээгүй тохиолдолд Засгийн газарт ашгаасаа хөрөнгө шилжүүлдэгтгүй. Энэтхэгийн Төв банк нь өөрийн хөрөнгийн хэмжээг активынхаа 8 хувь байлгахаар тогтоожээ. Төв банкуудад байх өөрийн хөрөнгийн зохистой хэмжээ нь тухайн банкны тайлан тэнцэлд гарч болзошгүй өөрчлөлтүүдээс хамаардаг. Харин энэ өөрчлөлтүүд нь Тухайн төв банкинд ямар үүрэг оногддог (гадаад нөөцөө барьж байдаг бол өөрийн хөрөнгийн хэмжээ ахиу байх гэх мэт) мөн ямар бодлого хэрэгжүүлж байгаа зэргээс шалтгаалдаг. Төв банкийг бага эсвэл бүр сөрөг өөрийн хөрөнгөтэй болгох нь түүний бие даасан байдал, мөнгөний бодлого хэрэгжүүлэх чадварт нь сөрөгөөр нөлөөлж болох юм. Төв банкны өөрийн хөрөнгө зөвхөн жилийн туршид хуримтлагдаж буй ашиг алдагдлын хэмжээгээр өөрчлөгдөж байгаад жилийн эцэст засгийн газарт ашиг хуваарилах тохиолдолд буурдаг. Өөрөөр хэлбэл Төв банкны ашиг, алдагдал буюу цаашилбал орлого, зарлага нь Төв банкны өөрийн хөрөнгөнд нөлөөлдгийнхөө хувьд түүний үйл ажиллаганд болон бодлого боловсруулалтад нөлөөлж болох юм. Иймд, ашиг олохыг зорилгоо болгон тавьдаггүй хэдий ч Төв банкны орлого, зарлага, ашигт ажиллагааны байдалд дүгнэлт гаргах шаардлага байдаг.

#### **МОНГОЛБАНКНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН**


Монголбанкны жилийн орлого, зарлагын тайлангаас харвал 2002, 2003, 2004 онуудад орлого болон зарлагын дүн тус тус их хэмжээгээр өсч, 2003 онд гэнэтийн их өсөлттэй гарсан. (Зураг 1.)

Хүснэгт 1-д 2000-2004 оны Монголбанкны орлого зарлагын тайланг дэд зүйл ангиудын нийт дунд эзлэх хувьтай нь хамт үзүүлэв. Хүснэгт 1-ээс харахад, жил бүрд орлого, зарлагын хэмжээ огцом хэлбэлзэж харилцан адилгүй дүнтэй байна. Орлого, зарлага ийнхүү хэлбэлзэлтэй гарах нь тухайн жилийн нийт банкны секторын хөгжил, мөнгөний бодлогын арга хэрэгсэл, алт, валютын захын идэвхжил, банкуудад олгосон зээлийн хэмжээ, засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ зэргээс хамаардаг.

#### **МОНГОЛБАНКНЫ ОРЛОГО**

Монголбанкны нийт орлогыг гүйлгээний болон захиргааны орлого гэсэн 2 үндсэн зүйл ангид хуваадаг. Сүүлийн 5 жилийн дунджаар нийт орлогын 99.8 хувийг гүйлгээний орлого бүрдүүлж байна.

**Зураг 1. Монголбанкны жилийн орлого, зарлага (сая төгрөг)**



Хүснэгт 1. Монголбанкны орлого, зарлагын тайлан (%, сая төгрөг)

	2000	2001	2002	2003	2004
<b>Нийт орлого</b>	<b>24,718.3</b>	<b>33,083.6</b>	<b>108,889.5</b>	<b>712,508.6</b>	<b>216,727.0</b>
Гүйлгээний Орлого	24,617.9 (99.6%)	32,972.2 (99.7%)	108,773.4 (99.8%)	712,332.1 (99.9%)	216,341.9 (99.8%)
Захиргааны Орлого	100.4 (0.41%)	111.4 (0.34%)	116.1 (0.11%)	176.5 (0.02%)	385.2 (0.18%)
<b>Нийт зардал</b>	<b>20,564.0</b>	<b>19,129.4</b>	<b>87,127.5</b>	<b>707,508.6</b>	<b>216,727.0</b>
Гүйлгээний Зардал	19,202.5 (93.38%)	17,246.6 (90.16%)	84,805.6 (97.34%)	704,837.1 (99.62%)	213,377.0 (98.45%)
Захиргааны Зардал	1361.6 (6.62%)	1882.8 (9.84%)	2321.9 (2.66%)	2671.5 (0.38%)	3350.0 (1.55%)
<b>Ашиг</b>	<b>4,154.2</b>	<b>13,954.2</b>	<b>21,762.0</b>	<b>5000000.0</b>	<b>0</b>

Харин захиргааны орлого нь түрээсийн, торгуулийн болон бусад орлогуудаас бүрддэг бөгөөд нийт орлогын нэг хүрэхгүй хувийг эзэлж байв.

### Гүйлгээний орлого

Гүйлгээний орлогыг дотор нь хүүний болон гүйлгээний бусад орлогууд гэж ангилдаг.

2000-2004 онд нийт орлогын дийлэнх буюу дунджаар 73.1 хувийг, сүүлийн 2 жилийн хувьд 97.1 хүртэл хувийг нь гүйлгээний бусад орлого эзэлж байв. Гүйлгээний бусад орлогын дийлэнх хэсгийг алт, валютын арилжааны болон гадаад валютын дахин үнэлгээний орлогууд бүрдүүлдэг.

Хүснэгт 2. Гүйлгээний бусад орлого

(сая төгрөгөөр)

	2001	2002	2003	2004
<b>Гүйлгээний бусад орлого</b>	<b>15,014.3</b>	<b>101,437.7</b>	<b>705,038.5</b>	<b>206,391.8</b>
Алтны Арилжааны орлого	10,068.1	37,547.2	101,198.6	74,378.4
Валютын арилжааны Орлого	4,621.8	9,395.6	30,144.1	22,268.3
Гадаад валютын дахин үнэлгээ	-	48,783.8	573,077.5	109,245.7

Дотоодын алт олборлогчдоос худалдан авсан алтыг мөнгөжүүлж, гадаадад худалдаж, байршуулснаар орж буй орлого нь Монголбанк Төв банкныхаа хувьд эдэлж буй онцгой эрхийнхээ дагуу олж байгаа орлого юм. Энэхүү орлогын хэмжээ нь алт олборлолт өсөхийн хирээр нэмэгдэж байдаг орлого юм. Монголбанкны аж ахуйн нэгжүүдээс худалдан авч буй алтны хэмжээгээр нөөц мөнгөний хэмжээ нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийг өсгөх нь цаашид инфляцийг хөөрөгдүүлэх сөрөг үр дагвартай байж болох юм. 2001-2004 онд Монголбанк нийт худалдан авсан алтныхаа 31.5-47.3 хүртэлхи хувьтай тэнцэх орлогыг алтны арилжаа хийснээр олжээ.

Хүснэгт 3. Алтны арилжааны орлого болон Монголбанкны алт худалдан авалт

	2001	2002	2003	2004
Монголбанк алт худалдан авсан дундаж үнэ (төгрөгөөр)	9,569.3	11,212.82	13,418.84	15,393.84
Нийт худалдан авсан алт (сая төгрөгөөг)	115,396.9	119,270.6	132,249.7	157,221.1
Алтны арилжааны орлого (сая төгрөгөөр)	10,068.1	37,547.2	101,198.6	74,378.4
Алтны арилжааны орлого/ /нийт худалдан авсан алтны		31.5 %	76.5%	47.3%

Валютын арилжааны орлого нь өнгөрсөн 4 жилд дунджаар Монголбанкны нийт орлогын 9.1 хувийг эзэлж байв. Төв банк ханшийг ямар нэг түвшинд тогтоон

барих, хамгаалах зорилгоор валютын арилжаа хийснээрээ алдагдал хүлээхэд хүрдэг. Харин Монголбанкны хувьд валютын арилжааны орлого тогтвортой өндөр хэмжээнд байгаа нь Монголбанкны гадаад талдаа нилээд идэвхтэй байдлаар валютын арилжаа хийж ирснээс гадна дотоодын зах зээл дээр хийж буй валютын арилжаанууд нь зах зээлийн нөхцлөөр хийгдэж буй арилжаа давамгайлж байгаа хэрэг юм. Ер нь төгрөгийн америк доллартай харьцуулсан ханш багаар боловч тогтвортой супларч байгаа бөгөөд манай гадаад актив гадаад пассиваасаа 3-5 дахин илүү байдаг нь Монголбанкинд валютын арилжаагаар ашиг олох нэг хүчин зүйл нь болдог.

Гадаад валютын дахин үнэлгээний орлого нь нийт орлогын тал буюу талаас илүү хувийг эзлэх болсон нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэхүү гэнэтийн өсөлтийн нэг шалтгаан нь санхүүгийн тооцооны аргачлалтай холбоотой байв. Учир нь Олон Улсын Валютын Сангаас гаргасан Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартын дагуу 2002 оноос гадаад валютын дахин үнэлгээний ашиг болон алдагдлын дансуудыг ашиглаж эхэлсэн. Ханшийн хэлбэлзлээс шалтгаалан Төв банкуудын гадаад валютаар илэрхийлэгдсэн актив болон пассивын дотоодын валютаар илэрхийлэгдэх үнэ цэнэ нь өсч, буурч байдаг. Энэ тохиолдолд гарах үнийн зөрүү буюу ашиг, алдагдал бол бодит бус ашиг, алдагдал гэж хэлж болох боловч Төв Банкны актив, пассивын дүng өөрчилж байдгаас орлого, зарлагын дансуудад оруулж бодох болжээ. 2002 онд энэхүү гадаад валютын дахин үнэлгээг долоо хоногт 1 удаа хийж гаргадаг байсан бол 2003 оноос өдөр тутам хийдэг болж улмаар 2003 оны ашиг урд оныхоос хэт өсөлттэй гарсан байж болох юм.

2000-2001 онуудад Монголбанкны нийт орлогод талаас илүү хувийг эзэлж байсан хүүний орлогууд 2002 оноос эхлэн буурсаар 2004 оны эцсээр нийт орлогын дөнгөж 2.2 хувийг эзэлж байв. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь тайлан дахь Гадаадын банкнаас орох хүүний орлого 2002 оноос эхлэн огцом буурсантай холбоотой юм. Монголбанкны гадаад валютын нөөцийн дийлэнх хэсгийг АНУ-ын Холбооны Нөөцийн Санд хадгаламж хэлбэрээр байршуулдаг байсан бөгөөд Холбооны Нөөцийн Сан 2002 онд хүүгээ буулгасантай холбоотойгоор хүүний орлого ийнхүү буурчээ. Түүнчлэн, дээрх хүү буурахын хирээр Монголбанк хадгаламжинд байршуулж байсан валютын эх үүсвэрийг валютын арилжаанд шилжүүлснээр валютын арилжааны орлогыг нэмэгдүүлжээ.

Засгийн газраас орох хүүний орлого, зээлийн хүүний орлого гэх мэт бусад хүүний орлогуудын нийт орлогод эзлэх жин бага бөгөөд Монголбанкны ашиг, алдагдалд мэдэгдэхүйц нөлөөлөхөөргүй байна. Эдгээр орлогууд нь нэрлэсэн

дүнгээрээ ч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа нь эдийн засаг дахь нийт хүүний түвшин багаар боловч буурч байгаатай бас холбоотой юм.

## МОНГОЛБАНКНЫ ЗАРДАЛ

Монголбанкны нийт зардал гүйлгээний болон захиргааны зардал гэсэн 2 үндсэн зүйл ангиас бүрддэг. Дээрхийн адилаар, 2000 – 2004 он хүртэлх 5 жилийн дунджаар Монголбанкны жилийн нийт зарлагын 95.8 хувийг гүйлгээний зардал эзэлж байна.

### Захиргааны зардал

Захиргааны зардлын гол бүрдүүлэгч хэсэг нь Монголбанкны ажилчдын цалингийн зардал байдаг бөгөөд энэ нь нийт зардалын хичнээн хувийг эзэлдгийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. МБ-ны ажилчдын цалингийн зардал, эзлэх хувь (сая төгрөгөөр, %)

	2000	2001	2002	2003	2004
МБ-ны ажилчдын цалингийн зардал	243.0	356.2	403.6	437.6	636.2
Захиргааны зардалд	17.9	18.9	17.4	16.4	19.0
Нийт зардалд	1.18	1.86	0.46	0.06	0.29

### Гүйлгээний зардал

Гүйлгээний зардлыг дотор нь хүүний болон бусад зардлууд гэж ангилдаг. 2004 оны эцэст Сангийн Яаманд төлснөөс бусад хүүний зардал нэрлэсэн дүнгээрээ өссөн хэдий ч эзлэх хувийн жин нь буурсаар байна. Тухайлбал, Монголбанкны нийт зардалд хүүний төрлийн зардлуудын эзлэх жин 2000 онд 18.1 хувьтай байсан бол 2004 оны эцсээр нийт зардлын 3.7 хувьтай тэнцүү болтлоо буурчээ, өөрөөр хэлбэл энэ нь хүүний бус бусад төрлийн зардлууд илүү хурдацтайгаар өсч байгааг илтгэж байна.

Монголбанкны хамгийн өндөр дүнтэй хүүний зардал нь Төв Банкны үнэт цаасны хүүний зардал бөгөөд 2001 онтой харьцуулахад 2004 оны эцсийн байдлаар 3.4 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өсчээ. Сүүлийн 3 жилийн хугацаанд үнэт цаасны хүүний зардал жилд дунджаар 1.1 тэрбум төгрөгөөр өсч байсан нь банкуудын илүүдэл нөөц системын хэмжээгээр нэмэгдэж улмаар ТБҮЦ-ны гаргах хэмжээг нэмэгдүүлсэнтэй шууд холбоотой.

Сүүлийн 4 жилийн хугацаанд Гадаадын банкинд төлсөн хүүний болон дотоодын банкуудын харилцах, хадгаламжид төлсөн хүүний зардлууд нь нийт зардлын 0.02-2.3

хувь байжээ.

Сангийн яаманд төлсөн хүүний зардал 2001-2003 онуудад өсч 2.3 тэрбум төгрөгт хүрч байсан бол 2004 оны эцэст өмнөх жилийнхэсээ 50 гаруй хувиар буурч 1.2 тэрбум төгрөг болжээ. Засгийн газарт төлсөн хүү 2003 онд өмнөх жилүүдэсээ огцом өссөн нь Төрийн Сангийн Нэгдсэн Данс (ТСНД)-ны үлдэгдэлд хүү төлж эхэлсэнтэй холбоотой бөгөөд тухайн жилдээ 1.8 тэрбум төгрөгийг хүүний төлбөрт шилжүүлжээ. Харин 2004 оны 5 дугаар сард ТСНД-ны үлдэгдэлд хүү төлөхийг зогсоосон нь тухайн онд засгийн газарт төлсөн хүүний зардал өмнөх оныхоосоо эргээд буурахад нөлөөлжээ. Энэхүү шийдвэр нь их өрийн тооцоогоор Засгийн газрын Монголбанкнаас авсан зээлд хүү тооцогдохгүй байсантай холбоотой. Эдгээр зардлууд нь нийт зардлын хэмжээтэй харьцуулахад мөн л ашиг, алдагдлын тайландаа нөлөөлөхүйц өндөр зардлууд биш юм.

2000-2004 онд нийт зардлын дийлэнх буюу дунджаар 73.1 хувийг, сүүлийн 2 жилийн хувьд 97.1 хүртэл хувийг гүйлгээний бусад зардал эзэлж байв. Гүйлгээний бусад зардлын задаргаа болон бүрэлдхүүн хэсгүүдийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 5. Гүйлгээний бусад зардал болон ТБҮЦ-ны хүүний зардал (сая төгрөг)

	2000	2001	2002	2003	2004
ТБҮЦ-ны хүүнд төлсөн зардал	2921.4	2856.9	2930.8	4568.6	6186.4
Гүйлгээний бусад зардал	7,238.6	12,773.2	79,066.2	696,913.3	197,191.3
-Мөнгөн тэмдэгтийн зардал	1,361.0	3,789.4	2,168.7	7,027.0	4,214.5
-Валютын арилжааны зардал	1,459.6	2,671.1	9,054.9	28,703.3	18,025.3
-Алтны арилжааны Зардал	4,067.1	6,115.7	26,185.7	102,197.8	70,159.5
Ройтерын зардал	351.0	197.0	206.9	216.9	242.1
Гадаад валютын дахин үнэлгээ	-	-	41,450.0	558,768.3	104,549.9

Валютын дахин үнэлгээний зардал 2003, 2004 онуудад Монголбанкны хамгийн өндөр зардал болох нь дээрхи хүснэгтээс харагдаж байна. Энэхүү зардал

нь дээр хэлсэнчлэн санхүүгийн тооцооны шинэ аргачлалаас үүдэн тайланд тусгагдсан зарлагын шинэ зүйл анги юм. Гадаад валютын дахин үнэлгээг 2003 оноос өдөр тутмаар хийдэг болсон нь энэхүү зардлын дүнг 2003 онд өмнөх жилийнхээсээ огцом өсгөхөд хүргэжээ.

Алтны арилжаа болон алт цэвэршүүлэхтэй холбогдон гарсан зардлууд нь санхүүгийн тайлан гаргах аргачлаалаар тодоройлогдоогүй хамгийн өндөр дүнтэй бодит зардал юм. 2003 онд Монголбанкны нийт зардлын хэмжээ өссөнөөс хувийн жин нь буурсныг эс тооцвол сүүлийн жилүүдэд алтны арилжааны зардлын нийт зардалд эзлэх жин тогтвортой 30 гаруй хувьтай байжээ. Алтны арилжаа болон цэвэршүүлэхтэй холбогдон гарсан зардлууд нь алтны арилжааны орлогоос байнга доогур төвшинд байсан хэдий ч илүү хурдацтай өсч байна. Тухайлбал, сүүлийн 4 жилийн хугацаанд алтны арилжааны орлого жилд дунджаар 120 хувиар өсч байхад зардал нь дунджаар 160 орчим хувиар өсчээ.

### АШГИЙН ХУВААРИЛАЛТ

Аль ч улсын Засгийн газрууд нь Төв банкны “хөрөнгө оруулагч” гэдэг утгаараа Төв Банкны тухайн жилд хуримтлагдсан ашгаас ямар нэг хэмжээгээр хүртэх эрхтэй байдаг.

Төв банкны тэнцэл дэх өөрийн хөрөнгө нь Засгийн газарт шилжүүлсэн ашгийн хэмжээгээр буурдаг. Төв банкны ашгаас хэдий хэмжээг нь Засгийн газарт шилжүүлэх вэ гэдгийг зарим улсуудад дүрэм заавраар тодорхойлдог бол заримд нь хулиар тогтоочихсон байх жишээтэй. Түүнчлэн, Төв банк нь өөрөө шийдвэрлэдэг, эсвэл Засгийн газар нь шийдвэр гаргадаг, эсвэл хоорондоо тохиролцдог гэх мэт улс болгон өөр өөрсдийнхөөр тодорхойлдог байна. (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Улсын төсөвт шилжүүлсэн төв банкны ашиг ДНБ-нд эзлэх хувиар.

	Төв банкны ашгаас Засгийн газарт шилжүүлэх хэмжээг хэрхэн тодорхойлдог вэ	2000	2001
Монгол	Ашгийн <40 хувь нөөцийн санд, бусдыг төсөвт	0.1	0.6
Өмнөд Солонгос	Ашгийн 90 хувь	0.2	0.7
Польш	<98 %,	0.7	0.4
ОХУ	Ашгийн 50 хувь	0.0	0.1
Австрали	Засгийн газрын шийдвэрээр, ТБ-тай зөвшилцдэг	0.5	0.2
Канад	100 хувь	0.2	0.2
Европын Холбоо	Төв Банкны шийдвэрээр	0.0	0.0
Хятад	Засгийн газрын шийдвэрээр	-	-

Эх: Central Banks; IMF, International Financial statistics

Монголбанк 2000 – 2004 онд нийтдээ 44.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж хуулийн дагуу нийгмийн хөгжлийн болон өөрийн хөрөнгийн бусад сангруудад хуварилалт хийж үлдэгдэл ашгийг Засгийн Газарт шилжүүлжээ (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Монголбанкны ашгийн хуваарилалт (сая төгрөгөөр)

	2000	2001	2002	2003	2004	Нийт
Ашиг	4154.2	13954.2	21762.0	5000.0	0	44870.4
Нийгмийн хөгжлийн сан	1000.0	3000.0	3000.0	-	-	7000.0
Өөрийн хөрөнгө				-	-	0
Дүрмийн сан		4000.0		-	-	4000.0
Ерөнхий нөөцийн сан				-	-	0
Дахин үнэлгээний сан	1654.2		7134.1		-	8788.3
Засгийн газарт	1500.0	6954.2	11627.9	5000.0	-	25082.1

### ДҮГНЭЛТ

Монголбанк 2001-2004 онуудад нийт 25.1 тэрбум төгрөгийн ашиг улсын төсөвт шилжүүлсэн байна<sup>1</sup>. Энэ нь дээрх онуудын нийт улсын төсвийн 1.1%, ДНБ-ий 0.4% байсан нь дэлхийн бусад орнуудын жишигтэй ойролцоо байв.

Монголбанкны гол орлого, зарлагууд нь алтны болон валютын арилжаа, улсын гадаад нөөцийг удирдах зэрэг үйл ажиллагаануудтай холбогдон гарч ирж байна. 2003 онд Монголбанкны тайлан дахь орлого, зарлагын хэмжээ нийтээрээ хөөрөгдсөн дүнтэй гарсан нь тухайн онд гадаад валютын дахин үнэлгээг өдөр тутам хийдэг болсон нь, мөн 2003 онд алтны болон валютын захын идэвхжил өндөр байснаар тайлбарлагдана.

2000-2002 онд алтны арилжаанаас олсон ашиг нь Монголбанкны нийт ашгийн дийлэнх буюу дунджаар 43.1 орчим хувийг эзэлж байсан бол 2003 онд алтны арилжаанаас 1.0 тэрбум орчим төгрөгийн алдагдал хүлээжээ.

2000-2003 онд Монголбанкны валютын арилжаанаас олсон ашиг дунджаар нийт ашгийн 12.2 хувийг эзэлж байв.

2000-2004 онуудад Гадаадын банкуудаас авах хүүний орлогыг эс тооцвол Монголбанк бусдад төлөх болон бусдаас авах хүүний зөрүүнээс жилд дунджаар 4.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байв.

Монголбанкны орлого, зарлагын тайланг үндэслэн нийт активийн болон өөрийн хөрөнгийн өгөөжийг сүүлийн 4 жилийн эцсийн байдлаар тооцоход ашигт ажиллагааны үзүүлэлтүүд 2001, 2002 онуудад тус тус өсч 2003 онд буурч, 2004 онд Монголбанк орлогоороо зарлагаа нөхөн ажиллажээ.

Хүснэгт 8. Монголбанк болон нийт банкуудын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2001	2002	2003	2004

<sup>1</sup> Энэхүү дүнг Монголбанкны балансаас авав. Үндэсний Статистикийн Газрын 2004 оны 12 дугаар сарын бүллетеень болон аудиторын тайлангууд өөр дүнг үзүүлж байв.

Монголбанкны нийт активын өгөөж	3.6 %	4.9 %	0.9 %	0
Банкны системийн нийт активын өгөөж (сарын дундаж үзүүлэлт)	5.9 %	4.3 %	3.1 %	2.5 %
Монголбанкны өөрийн хөрөнгийн өгөөж	33.9 %	65.2 %	12.2 %	0
Банкны системийн өөрийн хөрөнгийн өгөөж (сарын дундаж үзүүлэлт)	23.2 %	20.8 %	14.7 %	12.3 %

Нийт банкны системийн хувьд 2001-2004 онууд нь гол орлого оруулагч активезээлийн өрийн үлдэгдэл огцом өсч улмаар нийт активынх нь хэмжээ өндөр хурдацтайгаар өссөн жилүүд байлаа. Гэвч зээлийн хүү тодорхой хэмжээгээр буурсан, зардал өндөртэй хадгаламж, харилцах өссөнөөс шалтгаалан ашигт ажиллагааны үзүүлэлт нь буурч байна. Монголбанкны хувьд дээрхи хугацаанд нийт актив 1.4 дахин өсч, цэвэр орлого 2002 онд 21.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активынх нь өгөөж салбарын дундаж үзүүлэлтээс 0.6 хувиар давж байв. Өмнөх жилүүдэд банкуудын дунджаас өндөр байсан Монголбанкны нийт активийн болон өөрийн хөрөнгийн өгөөж 2003 онд үлэмж хэмжээгээр буурч 2004 онд орлого зарлагын тайлангаар Монголбанк ашиггүй ажиллажээ.